



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/101

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар баг Дэнж-4 48/1 тоотод байрлах 6209007826 нэгж талбарын 600 м<sup>2</sup> газрыг Отгонбаатарын Дулмаагын хүсэлтийн дагуу Омборын Гэрэлтуяад шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Омборын Гэрэлтуяад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2022 оны А/237 дугаар захирамжийн 78 дугаарт байгаа, газар эзэмших эрхийн 0000282985 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100201